



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/17

Мандалговь

Байгууллагын албан хаагчдыг Монгол
бичгийн цахим сургалтад хамруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хавсралтаат батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн 3.2.15 дахь заалт, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.2 дахь зүйлийн 7.2.2, 7.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ.

1.Байгууллагын албан хаагчдыг Монгол бичгийн цахим сургалтад хамруулсугай.

2.Цахим сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийг нэгдүгээр, үйл ажиллагаанд шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалтад шаардагдах сургагч багшийн хөлс 400,000 (Дөрвөн зуун мянга) төгрөгийг Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Саранзаяа)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагааг үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн (Б.Номингэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ХУЛАН

482412059

Орон нутгийн өмчийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
А.Ц. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



МОНГОЛ БИЧГИЙН ЦАХИМ СУРГАЛТАД
ХАМРАГДАХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Албан тушаалын нэр	Албан хаагчийн овог	Албан хаагчийн нэр
1	Газрын дарга	Сандаг	Хулан
2	Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	Норов	Гэрэлмаа
3	Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	Батсумьяа	Үүрийнтуяа
4	Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	Батбаяр	Номингэрэл
5	Нягтлан бодогч	Эрдэнэбилэг	Саранзаяа

----oOo----

Орон нутгийн өмчийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
А.Н.Т дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



МОНГОЛ БИЧГИЙН ЦАХИМ СУРГАЛТАД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Хэрэглэгдэхүүн	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт дүн
1	Сургагч багшийн хөлс	Төгрөг	80,000	5	400,000
Нийт:					400,000

---oOo---